

**УВС АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН  
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсө в	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
					Бүтэн жил		
Зорилго 1. Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.							
Зорилт 1.2.Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.							
1.1.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	-	Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь		Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	Тус хэлтэс эхний хагас жилийн байдлаар 551 эмнэлгийн 14,695 түүвэрт хяналт хийсэн. Хяналтаар гарсан алдаа дутагдлын талаар лавлагаа шатлалын 3 эрүүл мэндийн байгууллагад, анхан шатны 8 эрүүл мэндийн байгууллагад, нийт 11 зөвлөмж хүргүүлсэн. Мөн ЭМДЕГ-т ТҮЧЗХ-т нэмэлт хяналтаар орсон 9 түүвэрт хариу тайлбар бичиж хүргүүлсэн байна. -СЭМТ-үүдийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж үзэхэд, ихэнх Сумын эрүүл мэндийн төвд /шүдний тусламж үйлчилгээгээр гэрээлснээс бусад нь/ төлөвлөгөөт тусламж үйлчилгээ үзүүлдэггүй, архаг өвчний тусламж үйлчилгээ их үзүүлж байгаа нь харагдсан тул архаг өвчний тусламж үйлчилгээний төсвийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг ХАГГ-т уламжилж, төлөвлөгөөт дээр хувиарлагдсан тусламж үйлчилгээний төсвийн тодорхой хувийг архаг өвчний тусламж үйлчилгээний төсөв рүү шилжүүлж хуваарилуулсан. <b>Үр дүн: Тусламж үйлчилгээний чанар төлбөрийн хяналтын журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</b>	100 %

1.1.2	Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.		Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо		Статистик мэдээллийг 84 ЭМБ-д хүргэн олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна.	Лавлагаа шатлалын 4 ЭМБ, Анхан шатны 22 ЭМБ, Эмийн сан 58 нийт 83 ЭМБ-ыг Эрүүл мэндийн даатгалын 2024 оны тайланд тооцоо нийлж мэдээлэлээр хангаж мөн Увс аймгийн Статистикийн хэлтэст сар бүр нийт 5 удаагийн Эрүүл мэндийн орлого зарлагын мэдээг хүргүүлсэн.  <b>Үр дүн: Хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</b>	80%
1.1.3	"Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.		Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ-ийн 2024 оны 08 дугаар тогтоолыг мөрдөж байна. Гэрээ бүхий 84 ЭМБ-д хүргэн ажиллалаа.	. Шинэчлэгдсэн журмыг 85 ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажилласан байна.	ЭМДҮЗ-ийн 2024 оны 06-р тогтоол 2025 оны 04-р тогтоол болж шинэчлэгдсэнийг гэрээт 85 ЭМБ-дад мэйлээр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.  <b>Үр дүн: Шинэчлэгдсэн журмыг 85 ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажилласан байна.</b>	100 %
1.1.4	ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.		Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ 2024 оны 05 дугаар тогтоолыг мөрдөж байна. Гэрээ бүхий 22 анхан шатны ЭМБ-д хүргэн ажиллалаа.	Шинэчлэгдсэн журмыг 22 анхан шатны ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.	ЭМДҮЗ-ийн 2024 оны 06-р тогтоол 2025 оны 04-р тогтоол, ЭМДҮЗ-ийн 2024 оны 05-р тогтоол 2025 оны 03-р тогтоол болж шинэчлэгдсэнийг анхан шатны гэрээт 22 ЭМБ-дад мэйлээр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.  <b>Үр дүн: Шинэчлэгдсэн журмыг 22 анхан шатны ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.</b>	100 %

1.1.5	Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж ажиллана.	-	Санхүүжүүлсэн мөнгөн дүн -Хамрагдсан даатгуулагчийн тоо	ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолыг мөрдөж байна. 2024 онд 3675 иргэн хамрагдаж 596,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг баталгаажуулсан байна.	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн Нэгдсэн эмнэлгийн гүйцэтгэлд хяналт хийж, 1343 иргэний 230,720,000₮-ийн санхүүжилтийг баталгаажуулж олгосон.  <b>Үр дүн: Нийт 1343 даатгуулагч эрт илрүүлэг үзлэгт орж тусламж үйлчилгээ авсан гүйцэтгэлийг хянаж санхүүжилтыг олгосон байна.</b>	100 %
1.1.6	ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.		Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо	БТГ-т 3 санал хүргүүлсэн.	Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.	СЭМТ-үүдийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж үзэхэд ихэнх Сумын эрүүл мэндийн төвд /шүдний тусламж үйлчилгээгээр гэрээлснээс бусад нь/ төлөвлөгөөт тусламж үйлчилгээ үзүүлдэггүй, архаг өвчний тусламж үйлчилгээ их үзүүлж байгаа нь харагдаж байгаа тул архаг өвчний тусламж үйлчилгээний төсвийг нэмэгдүүлэх шаардлагатайг ХАГГ-т уламжилж, төлөвлөгөөт дээр хувиарлагдсан тусламж үйлчилгээний төсвийн тодорхой хувийг архаг өвчний тусламж үйлчилгээний төсөв рүү шилжүүлж хуваарилуулсан. <b>Үр дүн: ЭМ-ийн байгууллагуудын тусламж үйлчилгээний хүртээмжийн дүн шинжилгээ хийгдэж хэрэгжилтийг хангасан байна.</b>	100 %
1.1.7	"ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ"-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж	-	Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо	Увс аймгийн гэрээ бүхий 58 эмийн санд жагсаалтыг хүргүүлэн хяналт тавьж ажилласан.	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг холбогдох нэгжид тайлагнасан байна.	ЭМДҮЗ-ийн 2022 оны 11-р тогтоол болон, тус тогтоолд ЭМДҮЗ-ийн 2025 оны 11-р тогтоолоор орсон өөрчлөлтийг гэрээт 57 ЭМБ-дад мэйлээр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.  <b>Үр дүн: Журмын хэрэгжилтийг хангаж ажилласан .</b>	100 %

	хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.						
1.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4-т заасан "Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно" зорилтын хүрээнд							
1.2.1	Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.		Хүргүүлсэн саналын тоо	Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад 4 удаа санал хүргүүлсэн.	Эрх зүйн баримт бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	-2024 оны 06-р тогтоолын шинэчилсэн төсөлд 1 санал хүргүүлсэн. -ЭМДын шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журамд -1 ЭМД-ын тухай хуулийн шинэчлэн найруулахтай холбогдуулан тус хуулийн төсөлд-1 ЭМДҮЗ-ийн 04 тогтоолд-1 ЭМД-ын хамралтын судалгаанд -1 тус тус санал хүргүүлсэн байна.  <b>Үр дүн: Нийт 5 санал хүргүүлж ажилласан байна.</b>	100 %

1.2.2	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана.		Зөрчлийн хэргийн тоо	2024 оны аймгийн Прокурорын байгууллага тай хамтран гэмт хэрэгт холбогдсон 20 хүний судалгааг гарган өгч 17 хүнийг шүүхийн байгууллага Д шилжүүлсэн . Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн 29,1 сая төгрөг	Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.	Цагдаагийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу, гэмт хэрэг зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон 13 даатгуулагчийн ЭМБ-аас авсан тусламж үйлчилгээний зардлыг буруутай этгээдээс нэхэмжлэх, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийг төлөөлөх, иргэний нэхэмжлэгчээр оролцож, хамтарч ажилласан.  <b>Үр дүн: Хэрэгжилтийн биелэлтийг хангаж ажиллаж байна.</b>	100 %
2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.							
2.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1-т заасан “Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд:							
2.1.1	ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ 2.1.1  Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна		Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 35%	2025 онд 70 хувиас дээш хамруулна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 сарын 27-ны өдрийн А/12 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Увс аймгийн Эрүүл мэндийн даатгалын хамралт”-ын төлөвлөгөө дараах байдлаар биелсэн байна. 2025 оны 04 сарын 30-ны байдлаар малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 23,3%,  Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 123%,	40%
			Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 100.0	2025 онд 100 хувиас дээш хамруулна.		

			Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 44%	2025 онд 70 хувиас дээш хамруулна.	Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь 43%,	
			Байгууллага, аж ахуйн нэгжийн хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 105,6	2025 онд 100 хувиас дээш хамруулна.	Байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтнуудын хамрагдалтын хувь 100%. <b>Үр дүн: ЭМД-ын хамралтын төлөвлөгөө нийт дүнгээр 38%-ийн биелэлттэй байна.</b>	
2.1.2	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.		Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	2024 онд сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлан мэдээг гарган жилд 4 удаа ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган 4 удаа хүргүүлсэн байна.	ЭМДС-ийн 2025 оны 1-р улирлын тайланг гаргаж ЭМДЕГ-ынн СБХ-т хүргүүлсэн.  <b>Үр дүн: Тайлан мэдээ хугацаандаа хүргэгдсэн байна.</b>	100 %
2.1.3	ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.		Төвлөрүүлсэн мөнгөн дүн	2024 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай.	ЭМД-ын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	-ЭМД-ын санд 2025-ны 4-р сарын 30-ны байдлаар <b>3,521,955,180₮</b> -ийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 87,6%-тай байна. Үүнээс ажил олгогч даатгуулагчийн шимтгэлийн орлого <b>3,155,019,400₮</b> , биелэлт 87,4%, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, суралцагчдын шимтгэл <b>366,395,780₮</b> биелэлт 90%-тай байна. -Эрүүл мэндийн даатгалын хэлтэст биеэр болон цахимаар хандсан 1000 иргэний хүсэлтийг хүлээн авч газар дээр нь шийдвэрлэж, өөрийн гар утас, төхөөрөмж ашиглан <b>27,132,114₮</b> -ийг ЭМДСанд төвлөрүүлсэн байна.	70%

						<b>Үр дүн: Эрүүл мэндийн даатгалын орлогын төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна.</b>	
2.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т заасан “Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална” зорилтын хүрээнд:							
2.2.1	БСТ 2.2.1, БГТ-2.2.1 Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.		Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан	2024 онд 4 тэрбум төгрөгийн өглөгтэй 4 удаагийн тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна.	2024 оны эцэст гэрээт ЭМБ-дад нийт 5,07 тэрбум төгрөгийн өглөгтэй гарч, 2025 оны 1-р улиралд 2024 оны өглөг болох 5,07 тэрбум төгрөгийн санхүүжилтыг гэрээт ЭМБ-дад олгосон. Авлага байхгүй. <b>Үр дүн: Хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</b>	100 %
3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна							
3.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1-т заасан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна” зорилтын хүрээнд:							
3.1.1	БСТ 3.1.2, БГТ 3.1.1 Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.		Гэрээ дүгнүүлсэн байгууллагын тоо	2024 онд Лавлагаа-4 Эмийн сан-58 СЭМТ-18 ӨЭМТ-4 нийт 84 ЭМБ-ыг дүгнэсэн	2025 онд Лавлагаа-4 Эмийн сан-57 СЭМТ-18 ӨЭМТ-4 нийт 85 ЭМБ-уудын гэрээг хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна.	2024 оны 12 сард гэрээт 59 эмийн сангаас “Даатгалын гэрээг дүгнэх үнэлгээний хуудас”-аар гэрээт 57 эмийн сан тус бүрээр, гэрээт 22 ӨСЭМТ-өөс “Даатгалын гэрээг дүгнэх үнэлгээний хуудас”-аар гэрээт 22 ӨСЭМТ тус бүрээр, гэрээт 4 лавлагаа шатлалын ЭМБ-аас “Даатгалын гэрээг дүгнэх үнэлгээний хуудас”-аар гэрээт 4 лавлагаа шатлалын ЭМБ тус бүрээр гэрээг дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн.	100 %

			Гэрээний хэрэгжилтийн хувь	2024 онд гэрээний хэрэгжилт Лавлагаа-86,7% Эмийн сан-86% Анхан шат-78,4%	Гэрээний хэрэгжилтийн хувь 90 хувиас доошгүй байна.	Гэрээт 85 байгууллагын гэрээний хэрэгжилт 82,8%-тай байна Анхан шат - 72,3% Эмийн сан - 88,1% Лавлагаа - 88,3%,  <b>Үр дүн: Гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</b>	
3.1.2	2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	-	Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	ӨСЭМТ-22 эмийн сан-58 гэрээг байгуулан ажилласан.	Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн ЭМБ-уудтай гэрээ байгуулагдсан байна.	2025 онд нийт 57 эмийн сантай "Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх" гэрээг, 22 ӨСЭМТөвтэй "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ", нийт 4 лавлагаа шатлалын ЭМБ-тай нэмэлт гэрээ, нийт 83 ЭМБ-тай гэрээ хийн, хамтран ажиллаж байна. 2025 онд шинээр ЭМДЕГ-тай 2 эмийн сан гэрээ хийсэн ба гэрээ бүхий нийт 85 ЭМБ-тай хамтран ажиллаж байна.  <b>Үр дүн: нийт 85 ЭМБ гэрээ байгуулан ажиллаж байна.</b>	100 %
3.1.3	Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо, хэрэгжилтийн тайлан	Лавлагаа шатлалын гэрээт 4 байгууллагын г мэдээллээр хангаж, хэрэгжилтийг тайлагнасан	Журамд орсон өөрчлөлтийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, анхан шатны ЭМБ-уудад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.  <b>Үр дүн: Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж ажилласан.</b>	100 %

3.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2-т заасан “Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна” зорилтын хүрээнд:							
3.2.1	БГТ 3.2.1 Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.		Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн	Нийт 933 ЭМБ-д 33521 түүврийн хяналтыг хийж 13,7 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийн гүйцэтгэл хянагдсан.	Хуваарилагдсан түүвэрт нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хугацаанд нь журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хэрэгжүүлэн давхардсан тоогоор нийт 551 ЭМБ-д 14,695 даатгуулагчид үзүүлсэн тусламж үйлчилгээний төгрөгийн гүйцэтгэл хянасан байна.  <b>Үр дүн: Хуваарилагдсан түүвэрт нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн байна.</b>	100 %
3.2.2	БГТ 3.2.3 Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.		Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	83 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.	Гэрээт ЭМБ-дад ЭМДЕГ-тай гэрээ хийх, төсөв хуваарилах болон ЭМД-тай холбоотой гарсан асуудал, хяналтаар илэрсэн алдаа дутагдал, санхүүжилтын талаар цаг тухай бүрт мэдээлэл зөвлөгөө өгч, мэдээлэл солилцон ажиллаж байна.  <b>Үр дүн: Хэрэгжилтийг хангаж ажиллаж ойлголтын зөрүүг арилган ажиллаж байна.</b>	100 %
3.2.3	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна.		Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	албан шаардлага 2, Улсын байцаагчийн акт 6, Улсын ахлах байцаагчийн зөвлөмж 8, Улсын байцаагчийн зөвлөмж 26, бүртгэл хөтөлж хүргүүлсэн.	Тусламж, үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, лавлагаа шатлалын 3 эрүүл мэндийн байгууллагад, Анхан шатны 8 ЭМБ-д, 22 эмийн санд Эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулах зөвлөмжийг хүргүүлж ажилласан.  <b>Үр дүн: Хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</b>	100 %

3.2.4	БСТ 3.2.3, БГТ-3.2.2 Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.		Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо -Хяналт шалгалтын тайлан	2023 онд гэрээт 9 байгууллага д газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан.	Газар дээрх хяналт, шалгалт хийж, тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	<p>-Нэгдсэн эмнэлгийн даатгуулагчдад олгосон Төр хариуцах эмийн жагсаалтыг цахим системд оруулах үйл ажиллагаатай газар дээр нь танилцан, заавар зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>-Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 02 сарын 06-ны өдрийн №40 тоот, хавдрын мэс засал, болор солиулах хагалгаа, шүд эрүү нүүрний хагалгаа, мэдрэл нуруу нугасны хагалгааг орон нутагт нутагшуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, төвлөрлийг сааруулах зорилгоор 68 ОХБ-ийг нэмэлтээр гэрээ хийх албан хүсэлтийг үндэслэн, 2025 оны 02 сарын 12-ны өдрийн №10-31-07/01 дугаар бүхий Увс аймгийн нэгдсэн эмнэлэгт газар дээрх хяналт, шалгалт хийх ажлын удирдамж –ийн дагуу хяналтыг 2025 оны 03 дугаар сарын 06-04 дүгээр сарын 01-ны өдрүүдэд хийж тайланг ХАГГ-т хүргүүлэн, тэнцсэн 14 ОХБ-ээр гэрээ хийн хамтран ажиллаж байна.</p> <p>-Даатгуулагчаас ирсэн мэдээллийн дагуу “Ариун” болон “Өгөөмөр амин дэм” эмийн сангуудад газар дээрх хяналт хийн тайлбар мэдээлэл авч, үр дүнг даатгуулагчдад эргэн мэдэгдсэн.</p> <p><b>Үр дүн: нийт 4 удаагийн газар дээрх хяналт, шалгалт хийж, тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.</b></p>	100 %
4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.							
4.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т заасан “Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинэ” зорилтын хүрээнд:							

4.1.1	<p>ЗГҮАХ-2.1.9, БГТ 4.1.3 Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ.</p>		<p>-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо. -Тайлан</p>	<p>Орон нутгийн удирдлагаас байрны дэмжлэг авч албан хаагчдын ажиллах нөхцөл сайжруулсан.</p>	<p>Орон нутгийн удирдлагатай хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.</p>	<p>Ажилтануудын ажиллах нөхцөлд анхааран Увс аймгийн Засаг даргын ТГ-ын дарга У.Ганзориг, ЭМГ-ын дарга Х. Дашзэвэг нарын дэмжлэгээр ЭМГ-т шилжин байрлан ажлын байраа өөрчилсөн. Увс аймгийн 100-жил ойн арга хэмжээ, ЭМГ-ын байрны засвар зэрэгт албан хаагч бүр хандив өргөсөн. ЗДТГ-ын чиглэлийн дагуу аймагт болсон улсын уралдааны хүүхдүүдэд хандив өргөсөн зэрэг аймгийн зохион байгуулж буй арга хэмжээнд идэвхтэй оролцож байна. -Увс аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Шинэтгэлээр түүчээлсэн төрийн алба” арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан Увс аймгийн Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд, -Аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан аливаа зөрчлийг, Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хэрхэн бүртгэх тухай сургалтанд сууж мэдээлэл авч ажиллаж байна. <b>Үр дүн: Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллаж байна.</b></p>	90%
4.1.2	<p>Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна.</p>	-	<p>Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээ-1, сургалтын тоо-25</p>	<p>Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна.</p>	<p>-ЭМГ-ын дарга, ажилтан албан хаагчдад ЭМД-ын санхүүжилт болон тусламж үйлчилгээ, шимтгэл төлөлтийн хувь хэмжээний талаар сургалт хийсэн. -Гэрээт ЭМБ-дад, эмийн сангийн гэрээ хийх сургалт, -СЭМТ-үүдийн дарга, мэргэжилтнүүдэд 2023 оны 10-р тогтоол, 2024 оны 05, 06-р тогтоолын төслийн шинэчлэлийн танилцуулга, эрт илрүүлгийн багц, ЭМДШ-ийн хувь хэмжээний талаар сургалт, -Нэгдсэн эмнэлгийн дарга, эмч нарт 06-р тогтоолын төслийн шинэчлэлийн танилцуулга, эрт илрүүлгийн багц, ЭМДШ-ийн хувь хэмжээний талаар сургалт,</p>	

						<p>-Нэгдсэн эмнэлгийн сувилагч нарт 06-р тогтоолын төслийн шинэчлэлийн танилцуулга, эрт илрүүлгийн багцын, ЭМДШ-ийн хувь хэмжээний талаар сургалт,  -Хувийн эмнэлэг, ӨЭМТ-ийн эмч сувилагч нарт 2023 оны 10-р тогтоол, 2024 оны 05, 06-р тогтоолын төслийн шинэчлэлийн танилцуулга, эрт илрүүлгийн багц, ЭМДШ-ийн хувь хэмжээний талаар сургалт,  -Гэрээт эмийн сангийн эрхлэгч нарт ЭМДҮЗ-ийн 2022 оны 11-р тогтоолд ЭМДҮЗ-ийн 2025 оны 11-р тогтоолоор орсон өөрчлөлтийн талаар болон эрт илрүүлгийн багцын, ЭМДШ-ийн хувь хэмжээний талаар сургалтыг тус тус хийсэн.  -Хувийн эмнэлгийн шүдний эмч нар болон Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдэд 1-р ангийн сурагчдыг эрт илрүүлэгт хамруулах Эрүүл мэндийн сайд болон Боловсролын сайдын хамтарсан А/413, А/151 тушаалын талаар мэдээлэл өгч ажилласан.  -ӨСЭМТ-дийн эмч, сувилагч нарт 6 настуудын эрт илрүүлгийн багцын тусламж үйлчилгээ үзүүлэх тухай сургалтыг зүүмээр хийсэн.  <b>Үр дүн: Нийт 9 удаагийн сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулсан байна.</b></p>	
4.1.3	Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ.	-	Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо	2024 онд 17 контент мэдээллийг өөрсдөө бэлтгэн 504 иргэнд хүргэсэн.	2024 онд 150-аас доошгүй иргэн, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын талаарх мэдлэг, мэдээллийг хүргэсэн байна.	<p>-2025 оны 05 дугаар сарын 23-ны байдлаар Пэйж хуудасны хандалт буюу дагагчийн тоо 2496, пэйж хуудсанд нийт 288 контент оруулж, 750 гаруй иргэн лайк шэйр хийсэн байна.  -Зах худалдааны төвүүд болон гэрээт эмийн сангуудаар орж, ОНХХ-ээс гаргасан сурталчилгааны материал тараан байршуулж, олон нийтэд түгээж ажилласан.  <b>Үр дүн: Эрүүл мэндийн даатгалын мэдээ мэдээллийг хүргэж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</b></p>	100 %

4.1.4	<p><i>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.10</i></p> <p>Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ.</p>	-	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	151 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан.	Сэтгэл ханамжийн судалгаа авч, хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	<p>Аймгийн ӨЭМТ-үүдээр үйлчлүүлж буй 40 даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авч тайланг гаргаж, танилцуулсан.</p> <p>Нэгдсэн эмнэлгийн амбулаториор үйлчлүүлж буй 60 даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авч тайланг гаргаж, НЭ-т хүргүүлсэн.</p> <p><b>Үр дүн: 2 удаагийн давтамжтай сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгтгэн үр дүнг хүргүүлсэн.</b></p>	100 %
4.1.5	<p><i>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.15</i></p> <p>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.</p>	-	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь	Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 217, шийдвэрлэлт 100 хувь.	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	<p>Хэлтэст ирсэн албан бичиг 46, явуулсан албан бичиг 26, албан шаардлага 1 Улсын байцаагчийн зөвлөмж 33-ийн бүртгэл хөтөлж, цахимжуулан хадгалж байна.</p> <p>Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн.</p> <p><b>Үр дүн: Албан бичиг шийдвэрлэлтийн хувь бүрэн хангагдсан байна.</b></p>	100 %
4.1.6	<p>Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана</p>	-	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	Даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтийн хангаж тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	<p>-Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн, хариуцсан ажил үүргийн холбогдох мэдээ, тайлан судалгааг цаг хугацаанд нь гаргаж, удирдлагад танилцуулан, ЭМДЕГ-т хүргүүлсэн.</p> <p>-Гэрээт эмийн сангуудын болон анхан шатны ЭМТ-үүдийн гэрээг шинээр, Лавлагаа шатлалын 4 эмнэлэгтэй хэлэлцээр хийн, нэмэлт гэрээ хийсэн.</p> <p>-Байгууллагад ирсэн өргөдөл гомдол, явсан ирсэн бичгийн шийдвэрлэлтийн тайланг хагас жилээр гаргаж ЭМДЕГ-т хүргүүлсэн.</p> <p>-Цагдаагийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу, гэмт хэрэг зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон 5 даатгуулагчийн ЭМБ-аас авсан тусламж үйлчилгээний зардлыг буруутай</p>	100 %

						<p>этгээдээс нэхэмжлэх, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийг төлөөлөх, иргэний нэхэмжлэгчээр оролцсон.</p> <p>-ХАГГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу Нэгдсэн эмнэлгийн хавдрын мэс засал, болор солиулах, шүд эрүү нүүрний, мэдрэл нуруу нугасны хагалгаа орон нутагт нутагшуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, төвлөрлийг сааруулах зорилгоор 68 ОХБ-ийг нэмэлтээр гэрээлэх хүсэлтийн дагуу газар дээрх хяналт хийж, тайланг ХАГГ-т хүргүүлж, тэнцсан 14 ОХБ-ээр гэрээ хийн, хамтран ажиллаж байна.</p> <p>-Чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн Ч.Дарьжав, Аймгийн засаг даргын тушаалаар Элбэг өгөөж ӨЭМТ-ийн үйл ажиллагаа эрхлэх төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах комисст орж ажилласан.</p> <p><b>Үр дүн:</b> Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.</p>	
4.1.7	<p>Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь үнэн зөвөөр тайлагнана</p>	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	<p>ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 10 удаа гаргаж хэрэгжилт 100 хувь. Даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтийн хангаж тайланг</p>	<p>Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас хийгдсэн 16 удаагийн хуралд оролцож мэдээлэл авч, шуурхайн биелэлт 16 удаа хүргүүлж ажилласан байна.</p> <p>ЭМДЕГ-ын хэлтсийн дарга болон ерөнхий газрын удирдлагуудаас өгсөн чиглэл үүрэг даалгаварыг цаг тухай бүрт нь биелүүлэн ажиллаж байна</p> <p><b>Үр дүн:</b> Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.</p>	100 %	

				ЭМДЕГ-т хүргүүлсэн.			
4.1.8	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	-	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ГТ-ний биелэлтийн хувь	Хэлтсийн мэргэжилтэн гийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан	4 албан хаагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020.12.16-ны өдрийн 217 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан 4 зорилго 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулсан. Мөн хэлтсийн нийт 4 мэргэжилтэнд АТТ-ын тодорхойлолтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж нэмэлт ажлыг хуваарилан өгч ажиллаж байна. Хэлтэст ирсэн ажил үүргийг оновчтой хуваарилан өдөр тутмын удирдлагаар жигд ханган алдаа дутагдал гаргахгүй ажиллах тал дээр анхаарал тавьж, дээд газраас ирүүлсэн чиглэлийг мөрдөн ажиллаж байна.  <i>Үр дүн: ЭМДХ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсан.</i>	100 %
4.1.9	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Архивын нэгжийн тоо (боть)	2023 оны 25 архивын нэгжийг бүрдүүлж, албан бичиг хөтлөлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байна.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу 2024 оны баримтыг үдэж цэгцлэн, 19 хадгаламжийн нэгж үүсгэсэн.  <i>Үр дүн: 19 боть баримт хүлээлгэн өгсөн.</i>	100 %

				архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн.			
4.1.10	Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна.		Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо, Хэрэгжилтийн хувь		Албан хэргээ хос бичгээр хөтлөн явуулна.	-“Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Төрийн албаны зөвлөлийн 165 дугаар тогтоолын хэрэгжилт болон “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЭМДЕГ-аас монгол бичгийн албан бланк захиалан хэвлүүлсэн. 1 бичиг гаргаж төлөвлөсөн. Мөн абле системд албан бичгийн бүртгэлийг төлөвлөн тоон гарын үсгээр баталгаажуулан гаргаж байна. <b>Үр дүн: Хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</b>	70%
4.1.11	Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ.		Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо		Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна.	Цахим гарын үсгийг нэвтрүүлэн үйл ажиллагаанд ашиглаж байна. Албан бичиг солилцооны абле системд албан бичгийг төлөвлөн, мэргэжилтэн дарга хооронд шилжүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулан гаргаж байна. Хүргүүлсэн цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо-3  <b>Үр дүн: Хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</b>	100 %

4.1.12	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.		Хэрэгжилтийн хувь		Хэрэгжилтийг ханган тайлагнасан байна.	ЭМДЕГ-ын Тамгын газраас зохион байгуулсан Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь сургалтанд хамрагдсан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. <b>Үр дүн: Хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</b>	100 %
5 .Төрийн албаны тухай хууль, салбарын хууль дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх зорилтын хүрээнд:							
5.1	Эрүүл мэндийн даатгалын шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдийг тухай бүр нь судалж, танилцан бүрэн мэдлэгтэй болно.		Шинэчлэгдсэн тогтоол, шийдвэрүүдийг бүрэн судалсан эсэх		Сургалтанд бүрэн хамрагдсан байна.	БТГ-аас зохион байгуулсан ЭМДҮЗ-ийн 2023 оны 10-р тогтоол, 2024 оны 05, 06-р тогтоолын шинэчлэлийн танилцуулга сургалтанд хамрагдаж, ЭМДҮЗ-ийн 2024 оны 06-р тогтоол 2025 оны 04-р тогтоол, ЭМДҮЗ-ийн 2024 оны 05-р тогтоол 2025 оны 03-р тогтоол болж шинэчлэгдсэнийг судалж танилцсан. <b>Үр дүн: Шинэ гарсан тогтоол шийдвэрүүдийг судлан, мэдээлэл өгч ажиллаж байна.</b>	100 %
5.2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.4 ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсах сургалтанд тогтмол хамрагдана		Хамрагдсан сургалтын тоо	ЭМДЕГ-аас зохион байгуулсан 4 удаагийн сургалтанд хамрагдсан байна	ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтанд бүрэн хамрагдаж мэдлэг мэдээлэл авсан байна.	-БТГ-аас зохион байгуулсан Төр хариуцах эмийн сургалтанд, -БТГ-аас зохион байгуулсан ЭМДҮЗ-ийн 2023 оны 10-р тогтоол, 2024 оны 05, 06-р тогтоолын шинэчлэлийн танилцуулга сургалтанд, ЭМДЕГ-ын Тамгын газраас зохион байгуулсан Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь сургалтанд, БТГ-аас Лавлагаа шатлалын ЭМБ-тай гэрээ хийх тухай сургалтанд, -ХАГГ-аас зохион байгуулсан Эмийн сангийн гэрээ хийх тухай, анхан болон лавлагаа шатны ЭМБ-уудтай 2025 онд гэрээ байгуулах талаар зааварчилгаа, чиглэл өгөх сургалтанд, -ХАГГ-аас зохион байгуулсан 6 настнуудын эрт илрүүлгийн сургалтанд, -ХАГГ-аас зохион байгуулсан улсын лавлагаа шатлалын ЭМБ-уудтай хийсэн хэлэлцүүлэгт,	100 %

						<p>-ЭМДЕГ-ын Тамгын газраас зохион байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө бичих, ERP ашиглах сургалтанд тус тус хамрагдсан.</p> <p>-Тамгын газраас зохион байгуулсан "Мэдээллийн цаг хөтөлбөр" сургалтанд тухай бүр хамрагдсан.</p> <p><b>Үр дүн: Нийт 9 сургалтанд хамрагдаж мэдээлэл авсан байна</b></p>
5.3	Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ.		Хамрагдсан сургалтын тоо	Нийт 18 удаагийн сургалтанд оролцсон.	Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна.	<p>-Аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан аливаа зөрчлийг, Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хэрхэн бүртгэх тухай сургалтанд,</p> <p>-Увс аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан "Шинэтгэлээр түүчээлсэн төрийн алба" арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан Увс аймгийн Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд,</p> <p>-ЭМГ-ын тархвар судлаач Наранбатын "Хүний папилома вирусын эсрэг Гардисал вакцин"-ы танилцуулга сургалтанд,</p> <p>-Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Архив албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад зориулсан сургалтанд тус тус хамрагдсан.</p> <p>-МУ-ын Эрүүл мэндийн сайдын, эрүүл мэндийн салбарын албан хаагчидтай болон иргэдтэй хийх уулзалтанд,</p> <p>-Монгол улсын УИХ-ын дарга болон УИХ-ын гишүүдийн иргэдтэй хийх уулзалтанд хамрагдаж төр засгийн бодлого, шийдвэрийн талаар мэдээлэл авсан.</p> <p><b>Үр дүн: Нийт 6 сургалтанд хамрагдаж мэдээлэл авсан байна</b></p>

5.4	Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулах сургалтанд хамрагдах		Хамрагдсан сургалтын тоо		Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилж, Монгол бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна.	-Төрийн албаны зөвлөлийн 165 дугаар тогтоолд даалгасны дагуу Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн ур чадвар, мэдлэгийг сайжруулах зорилгоор монгол бичгийн мэдлэгээ сайжруулах зорилгоор "Монгол бичиг" пэйж хуудсыг даган уншиж бичих чадвараа дээшлүүлж байна. Үр дүн: Хамрагдсан албан ёсны сургалтанд сууж сертификат авсан бөгөөд одоо суурь мэдлэгээ дээшлүүлэн ажиллаж байна.	100 %
-----	--	--	--------------------------	--	---	---	-------

л

Төлөөлөгөөг үнэлсэн:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:  
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

Тайлагнасан:  
УВС АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Төсвийн шууд захирагч

/ С.ЭНХБОЛД /

Нэгжийн дарга

/ Б.ОЮУНЦЭЦЭГ /

2025.06.24

Нэгжийн дарга

/ Б.БУМБАЯР /

2025.05.26

